



 БАТАЛСАН:
 МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ ТӨХ.К-ийн
 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
 О.БАТНАСАН

КОМПАНИЙН ХЭМЖЭЭНД АВЛИГЫН ИНДЕКСИЙГ БУУРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД
 2021-2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах газар нэгж
Хяналт шалгалт, дотоод хяналт, аудитын чиглэлээр			
1.	Компанийн хяналт шалгалт, дотоод хяналт, аудитын нэгжийн ажлыг эрчимжүүлэх, Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, хараат бус байлгах, тэдгээрийн чиг үүргээ биелүүлэхэд нь хүний нөөц, санхүүжилтийн хувьд хангалттай байлгах	Жил бүр	Хяналт, шалгалтын газар Дотоод аудитын нэгж Өмч хамгаалах зөвлөл
2.	Төсөв, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн төлөвлөлт, зарцуулалт үр дүнтэй байдалд дотоод аудитын нэгж дүн шинжилгээ хийж, дараагийн төлөвлөлтөд санал өгч байх үйл ажиллагааг хэвшүүлэх	Хагас жил тутам	Дотоод аудитын нэгж
3.	Эрх бүхий дээд байгууллагын өгсөн үүрэг, даалгавар, зөвлөмж, чиглэлийн дагуу хяналтын шалгалтын болон дотоод аудит, хяналт хийх төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх, тайлагнах	Тухай бүр	Хяналт, шалгалтын газар Дотоод аудитын нэгж
4.	Эрсдлээс урьдчилан сэргийлэх журмыг хэрэгжүүлэх, компанийн үйл ажиллагаанд учирч болох сөрөг нөлөөлөл, үүсэх магадлал, үр дагавар, түүнд тохирсон арга хэмжээг оновчтой төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах	Жил бүр	Дотоод аудитын нэгж Эрсдлийн хороо
5.	Эрсдэлд суурилсан хяналт шалгалт хэрэгжүүлэх, хяналт шалгалтыг хариуцлага тооцох бус урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах	Жил бүр	Хяналт, шалгалтын газар Эрсдлийн хороо

Төсөв, санхүүгийн чиглэлээр			
6.	Компанийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үр ашигтай төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах	Жил бүр	Санхүү-эдийн засгийн газар Ерөнхий нягтлан бодогч Ахлах эдийн засагч
7.	Компанийн эдийн засаг, төсөв, санхүүд хийсэн аудитын байгууллагын акт, албан шаардлага, зөвлөмж, дүгнэлтийн мөрөөр хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлэх, үр дүнд анализ, шинжилгээ хийж байх	Тухай бүр	Санхүү-эдийн засгийн газар Ерөнхий нягтлан бодогч Ахлах эдийн засагч Дотоод аудитын нэгж
8.	Компанийн эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдалд байнга хяналт тавих, эд хариуцагч нарын хариуцлагыг дээшлүүлэх	Жил бүр	Санхүү-эдийн засгийн газар Өмч хамгаалах зөвлөл Дотоод аудитын нэгж
9.	Компанийн төсөв, санхүүгийн ил тод байдал, мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасны дагуу үнэн зөв хөтлөх	Тогтоосон хугацаанд	Санхүү-эдийн засгийн газар Ерөнхий нягтлан бодогч Ахлах эдийн засагч
10.	Компанийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил, үйлчилгээг санхүүжүүлэхгүй байх, хэрэв шаардлагатай ажил, үйлчилгээнд төсөв, зардал гаргах тохиолдолд Эрсдлийн хороогоор хэлэлцүүлж шийдвэрлүүлэх	Тухай бүр	Санхүү-эдийн засгийн газар Ерөнхий нягтлан бодогч
Худалдан авах ажиллагааны чиглэлээр			
11.	Худалдан авалтын ажиллагаанд нээлттэй, ил тод байдлыг хангах, чөлөөт өрсөлдөөнийг бий болгох, хүнд суртал, чирэгдлийг арилгах, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын туслалцаа авах, тэдгээрийн төлөөллийг оролцуулах	Жил бүр	Санхүү-эдийн засгийн газар Менежер, Худалдан авалтын мэргэжилтэн
12.	"Цахим худалдан авах ажиллагаа" -ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулах	Тухай бүр	Санхүү-эдийн засгийн газар Менежер Худалдан авалтын мэргэжилтэн
13.	Худалдан авах ажиллагааны дүнд гэрээ байгуулж, гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийг хөтлөх, тендерт оролцох эрхийг хязгаарлах талаар эрх бүхий байгууллагад мэдээлэх	Жил бүр	Санхүү-эдийн засгийн газар Менежер Худалдан авалтын мэргэжилтэн

14.	Худалдах авах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүн, сонгон шалгаруулах ажлын хэсэгт дотоод аудит, хяналтын ажилтанг, Өмч хамгаалах зөвлөлийн гишүүдээс оролцуулж байх, дүн шинжилгээ хийлгэх	Тухай бүр	Санхүү-эдийн засгийн газар Менежер Худалдан авалтын мэргэжилтэн
15.	Худалдах авах ажлын үр дүн, бараа, ажил үйлчилгээг хүлээн авахад Өмч хамгаалах зөвлөлийн гишүүдийг байлцуулж байх.	Тухай бүр	Санхүү-эдийн засгийн газар Менежер Өмч хамгаалах зөвлөл
16.	Худалдах авах, сонгон шалгаруулалтын талаар гарсан гомдол мэдээллийг хянан шийдвэрлэх, түүнд дүн шинжилгээ хийх	Тухай бүр	Менежер, Худалдан авалтын мэргэжилтэн Дотоод аудитын нэгж
17.	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, гэрээ байгуулахаас өмнө хариуцсан газар, нэгж холбогдох техникийн тодорхойлолт, ажлын болон техникийн даалгаврыг заавал боловсруулж, түүнийг газар, нэгжийн дарга нар батлах, улмаар Гүйцэтгэх захиралд танилцуулж зөвшөөрөл авсаны үндсэн дээр худалдан авалтыг зохион байгуулах	Тухай бүр	Газар, нэгжийн дарга Худалдан авалтын мэргэжилтэн Хуулийн мэргэжилтэн
18.	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдалтай холбогдсон мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хөтлөн явуулах, хяналт тавих, тайлагнах	Жил бүр	Менежер, Худалдан авалтын мэргэжилтэн
Захиргаа, удирдлагын чиглэлээр			
19.	Компанийн үйл ажиллагаа, ажлын бүх түвшинд газар, нэгжийн харилцан уялдаатай байдлыг хангуулах, мэдээлэлтэй байх	Жил бүр	Захиргаа, удирдлагын газар
20.	Цахим орчинд ил тод байдлыг дээшлүүлэх, компанийн зүгээс үзүүлж байгаа ажил, үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх	Жил бүр	Захиргаа, удирдлагын газар
21.	Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд компанийн үйл ажиллагаа, үзүүлэх ажил, үйлчилгээ, хүний нөөц, төсөв, санхүү, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, сонгон шалгаруулалтын тухай мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулах	Жил бүр	Захиргаа, удирдлагын газар

22.	Хуулийн этгээд, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулах, өргөдөл, гомдлын хайрцаг, харилцах утсыг ажиллуулах	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар
23.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хүний нөөцийн сул орон тооны зарыг цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлаж байх	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар
24.	Хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрмийг шинэчлэх, авлигаас ангид байх зүйл, заалтыг тусгаж өгөх, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох, дүрэм, журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх	2021 онд	Захиргаа, удирдлагын газар
25.	Ёс зүйн зөрчил, үйлдэлд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцэх арга хэмжээ авах	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар
26.	Төрийн өмчит компанийн хэвлэл мэдээллийн аж ахуйн нэгж, байгууллагаар хийлгэсэн сурталчилгаа, мэдээлэл, нийтлэл, нэвтрүүлэгт зарцуулсан хөрөнгө, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй хамтран ажиллах чиглэлээр байгуулсан гэрээг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлэх, хэвлэл мэдээллийн гүйцэтгэгчийг нээлттэй сонгон шалгаруулах	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар
27.	Иргэд, хуулийн этгээдийн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх	2021 онд	Захиргаа, удирдлагын газар
Хууль, эрх зүйн чиглэлээр			
28.	Компанийн зохион байгуулалтын газар, нэгж бүрт хууль, эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх	Жил бүр	Хууль, эрх зүйн газар

29.	Компанийн газар, нэгжээс боловсруулсан албан бичиг, гэрээ, хэлцлийн төслийг хянуулж байх, хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах	Тухай бүр	Хууль, эрх зүйн газар
30.	Гүйцэтгэх захирлын зөвшөөрөл, газар, нэгжийн дарга нарын цохолт, техникийн тодорхойлолт, ажлын болон техникийн даалгаваргүй, төсөв, хөрөнгө, оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй гэрээ, хэлцэл байгуулахгүй байх	Тухай бүр	Хууль, эрх зүйн газар
31.	Авлига, ашиг, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургалт, хөндлөнгийн байгууллагаар ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийлгэх, түүнд шаардагдах зардал, төсвийг шийдвэрлүүлэх, эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авах	Жил бүр	Хууль, эрх зүйн газар
32.	Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн авлигатай тэмцэх зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Тухай бүр	Хууль, эрх зүйн газар
33.	Иргэн, хуулийн этгээдтэй байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж байх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах	Тухай бүр	Хууль, эрх зүйн газар

оОо